



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ ИРГЭН НИЙГМИЙН ДААТГАЛД ХЭРХЭН ХАМРАГДАХ ВЭ?



Нийгмийн даатгалд даатгуулсан
тухай гэрээ

20... оны Дугаар.....

Тогтвортой бичил уурхай төсөл


2014 он



Энэ хүн бол бичил
уурхайгаас ашигт
малтмал олборлогч 50
настай, Сүрэн.

Сүрэн хэвлэлд нийтлэгдсэн
нийгмийн даатгалын тухай
материалтай танилцаад “Би
1991 оноос өмнө улсад 8
жил, түүнээс хойш 20 жил
хувиараа ажилласан, сүүлийн
5 жил бичил уурхайгаас
ашигт малтмал олборлож
байна. 10 жил болоод 60 нас
хүрэх нь” гэж бодлогоширно.
Сумынхаа нийгмийн даатгалын
байцаагчтай уулзаж, нийгмийн
даатгалд даатгуулах нь зөв
юм байна шүү гэж бодоод сумын Тамгын газар орохоор
яаран гарлаа.





Энэ хүн сумын нийгмийн
даатгалын байцаагч
Дулмаа

Иргэн Сүрэн
нийгмийн даатгалын
байцаагч Дулмаатай
уулзав.



Сүрэн: Би нийгмийн даатгалд даатгуулах хүсэлтэй байна. Даатгуулснаар надад ямар ашиг, тустай вэ? Би одоо бичил уурхайд ашигт малтмал олборлох ажил эрхэлж байгаа юм.

Дулмаа: Та сайн дурын хэлбэрээр нийгмийн даатгалд хамрагдаж болно. Харин эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна. Нийгмийн даатгалд даатгуулснаар:

- Та 60 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.
- Мөн ажиллаж байх хугацаандаа биедээ гэмтэл авах, бусад шалтгаанаар өвчлөн хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр эсвэл хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авна.
- Бүр муугаар бодоход, нас барахад таны асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй хүмүүс тань тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах боломжтой.
- Та ханиад томуу тусаад эмнэлэгт хэвтлээ гэхэд эмчилгээний зардлыг даатгалын сангаас төлнө шүү дээ.



Сүрэн: Тэгвэл ч нийгмийн даатгалд хамрагдах нь өөрт ч, үр хүүхдэд ч тустай юм байна.

Дулмаа: Тийм шүү. Та тэгээд нийгмийн даатгалд даатгуулах уу?

Сүрэн: Тэгнэ ээ. Даатгуулахад ямар бичиг, баримт хэрэгтэй вэ?

Дулмаа: Таны иргэний үнэмлэх байхад л болно. Таны сарын орлого хэд орчим байдаг вэ?

Сүрэн: Иргэний үнэмлэх байгаа. Миний сарын орлого янз бүр дээ. Дунджаар 250.000 төгрөг байгаа даа.

Дулмаа: Та нийгмийн даатгалын дэвтэр урьд нь нээлгэсэн үү?

Сүрэн: Үгүй.

Дулмаа: Тэгвэл таны 2 хувь цээж зураг хэрэгтэй юм байна.

За одоо нийгмийн даатгалд хамрагдсан тухай гэрээ байгуулья. Таны мэдүүлсэн 250.000 төгрөгийн орлогоос 12 хувиар тооцож, сар бүр 30.000 төгрөгийн шимтгэлийг энэ гэрээнд заасан хугацаанд төлнө.

Сүрэн: Энэ 12 хувь гэдэг нь ямар учиртай юм бэ?

Дулмаа: Сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалын гурван төрөлд даатгуулна. Энэ гурван даатгалын төрөлд төлөх шимтгэлийн хувь хэмжээ нийтдээ 12 хувь болж байгаа юм. Өөрөөр хэлбэл та сарын орлогоосоо тэтгэврийн даатгалд 10%, тэтгэмжийн даатгалд 1%, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 1%-иар тус тус тооцож шимтгэл төлнө гэсэн үг.

Харин та нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаад даатгалын санд 3 сар шимтгэл төлсөн бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй болно.

Та бичил уурхайд ажилладаг болохоор би таньд болзошгүй эрсдэл тохиолдсон үед хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хэрхэн яаж бодож олгохыг тайлбарлаж өгье.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж, бүтэн ажилласан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлсний дунджаас нийтдээ 5 хүртэл жил ажилласан бол 50 хувиар, 5-14 жил ажилласан бол 55 хувиар, 15 түүнээс дээш жил ажилласан бол 75 хувиар бодож олгодог. Та нийтдээ 8 жил 3 сар ажилласан гэвэл 55 хувиар бодно гэсэн үг.



Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно. Эхлээд нэг ажлын өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлогыг бодъё. Гурван сарын орлогын дүн 750.000 ($250.000 + 250.000 + 250.000$) төгрөг, ажилласан хоног нийтдээ 64 ($21 + 21 + 22$), нэг ажлын өдөрт ногдох орлого 11.718.75 ($750.000 : 64$) төгрөг байна. Одоо ажлын нэг өдөрт ногдох тэтгэмж 6.445 ($11.718.75 \cdot 55\%$) төгрөг, эмнэлэгт ажлын 20 хоног хэвтэж эмчлүүлсэн гэвэл, уг хоногоо 6.445 төгрөгөөр үржүүлэхэд 128.900 төгрөг болно. Энэ бол таны авах хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ юм.

Сүрэн: За баярлалаа. Нийгмийн даатгал ч үнэхээр л хэрэгтэй юм даа. Хэдэн жил ажилласнаас хамаарч тэтгэмжийн хэмжээ нь тогтоогддог юм байна шүү дээ. Олон жил даатгуулах нь ашигтай юмаа. Байцаагчаа, би нэг зүйл асууж болох үү?

Дулмаа: Бололгүй яхав.

Сүрэн: Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ямар болзол хангасан байх ёстой вэ, ямар баримт бичиг бүрдүүлэх талаар надтай хамт ажилладаг хүн асуугаад ирээрэй гэсэн юмсан.

Дулмаа: Нийтдээ 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, 60 нас хүрсэн хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, 55 настай эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.

Мөн төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн, 50 нас хүрсэн даатгуулагч эх өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах боломжтой.

Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн 60 настай эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авч болно.

Түүнчлэн 20-иос доошгүй жил шимтгэл төлж ажилласан даатгуулагч уг ажилласан жилийнхээ 7 жил 6 сараас 12 жил 6 сард нь газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан бол 45-55 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Одоо өндөр насны тэтгэвэр тогтоолгоход ямар материал бүрдүүлэх талаар хэлж өгье.

- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр
- ✓ 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр

- ✓ Шимтгэл төлсөн сүүлийн 20 жил доторх дараалсан 5 жилийн цалингийн тодорхойлолт
- ✓ Иргэний үнэмлэх
- ✓ Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар
- ✓ Цээж зураг 2 хувь
- ✓ Хэрвээ хөдөлмөрийн дэвтэр байхгүй эсхүл тушаал, шийдвэрүүд нь засвартай бол ажиллаж байсныг нь нотлох архивын лавлагаа, шүүхийн шийдвэр шаардлагатай болно
- ✓ Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл

Сүрэн: Тэгвэл тахир дутуугийн тэтгэврийг хэдэн жил ажилласан, ямар шалгуур хангасан хүн авах вэ?

Дулмаа: Нийтдээ 20-иос доошгүй жил эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлж ажилласан даатгуулагч ердийн өвчин ахуй ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй.

Мөн дээрх шимтгэл төлсөн хугацааг хангаагүй, нийтдээ 3-аас доошгүй жил шимтгэл төлсөн байвал тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож болно.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

Сүрэн: Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг сайн дураараа төлсөн хүн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг авах уу?

Дулмаа: Авна. Гэхдээ тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

Тэтгэмжийн даатгалд сайн дураар даатгуулсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг олгохдоо сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувиар бодож, 4 сарын хугацаанд олгодог.



Сүрэн: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болвол ямар тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах вэ?

Дулмаа: Сайн дураараа даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, тахир дутуу болох, нас барах тохиолдолд дараах тэтгэвэр, тэтгэмжийг тогтоолгон авах, мөн төлбөр үйлчилгээ авах эрхтэй. Үүнд:

- ✓ Тахир дутуугийн тэтгэвэр
- ✓ Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- ✓ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- ✓ Хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопеди) хийлгэсэн үнийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас төлөх

- ✓ Тахир дутуу болсон даатгуулагчийн сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлыг төлүүлэх
- ✓ Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх очих унааны зардлыг тухайн үеийн мөрдөж байгаа галт тэрэг, автомашины тарифаар бодож олгоно.



Мөн даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

Сүрэн: Ямар тохиолдлыг үйлдвэрлэлийн осол гэж үзэх вэ? Осолд орсноо хэнд эхлээд мэдэгдэх ёстой вэ?

Дулмаа: Дараах нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осолд даатгуулагч өртсөн тохиолдолд дээрх тэтгэвэр, тэтгэмжийг авах боломжтой. Үүнд:

- ✓ Ажлын байрандаа болон бусад газарт ажил үүрэг гүйцэтгэх явцад
- ✓ Ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед
- ✓ Ажилдаа ирэх буцах замд.

Үйлдвэрлэлийн ослын тухай осолдогч өөрөө буюу осол гарсаныг анх харсан хүн ажлын олгогч (сумын Засаг даргын тамгын газар)-д яаралтай мэдэгдэнэ.

Харин даатгуулагч дур мэдэн ажлын байраа орхиж яваад, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үедээ биед гэмтэлд учруулсан нь нотлогдсон тохиолдолд түүнд тэтгэвэр тэтгэмж, төлбөр олгохгүй.

Сүрэн: Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч үүрүүл мэндийн даатгалын шимтгэлээ хэрхэн төлөх вэ?

Дулмаа: Бичил уурхайд ажиллагч нь “хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн” гэсэн ангилалд хамаарах тул татварын албанд гаргасан орлогын хэмжээг үндэслэн 1 хувиар тооцон шимтгэлээ төлнө. Хэрвээ сарын орлого нь 250.000 төгрөг гэвэл сард 2.500 төгрөг жилдээ 30.000 төгрөгийг даатгалын санд төлөөд л жилдээ та 1.328.000 төгрөгийн эмчилгээний зардлыг даатгалын сангаас гаргуулах боломжтой шүү дээ.

Сүрэн: За баярлалаа. Бид ах дүүгээрээ бичил уурхайгаас ашиг малтмал олборлодог. Тэдэндээ нийгмийн даатгалын ач холбогдлын талаар тайлбарлаж, тэднийг бас даатгалд хамруулна аа. Ер нь “хэлж ирэхгүй, хийсч ирдэг” зовлон бэрхшээлтэй үед нийгмийн даатгал л тус болохыг ах нь маш сайн ойлголоо.

Дулмаа: Тийм ээ. Нийгмийн даатгал таны ч, бидний ч ирээдүйн нийгмийн баталгаа шүү дээ. Баяртай.

Тогтвортой бичил уурхай төсөл

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Олимпийн гудамж 12 "Sky Plaza
business center" 2-р давхар
Ш/х 58, Улаанбаатар 210648
Зил код 14210 Монгол улс

Утас: +976 11 328848
Факс: +976 11 322415

www.sam.mn,
www.swiss-cooperation.admin.ch/mongolia/

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар

211238 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Бага тойруу

Утас: +976 11 329392
Факс: +976 11 320716

www.ndaatgal.mn

Тогтвортой бичил уурхай төслийн санхүүжилтээр хэвлэв.

© Энэхүү гарын авлагыг худалдаалахыг хориглоно.